



## ХӨӨН ХЭЛЭЛЦЭХ ХУГАЦАА БА ОЛОН УЛСЫН ТҮРШЛАГА STATUTE OF LIMITATIONS AND INTERNATIONAL EXPERIENCE

Гэрэлийн Батжаргал<sup>1</sup>

University of Internal Affairs, E-mail: [batjargal@uia.edu.mn](mailto:batjargal@uia.edu.mn), <https://orcid.org/0009-0006-8470-3695>

### ӨГҮҮЛЛИЙН ТУХАЙ

#### Түлхүүр үгс:

Хөөн хэлэлцэх хугацаа, Англи-Саксоны, Эх газрын эрх зүйн бүл, материаллаг, процессын эрх зүй

#### Keywords:

Statute of limitations, Anglo-Saxon, Continental legal tradition, substantive law, procedural law

#### Нийтлэлийн түүх:

Хүлээн авсан: 2025, 9 сар  
Шинэчилсэн: 2025, 10 сар  
Зөвшөөрсөн: 2025, 10 сар

#### Article history:

Received Sep, 2025  
Revised Oct, 2025  
Accepted Oct, 2025

### ХУРААНГУЙ

Хөөн хэлэлцэх хугацааны агуулга, мөн чанар, зорилгыг тодорхойлох онол, үзэл баримтлал, зарчим болон түүнийг тоолох (эхлэх, түр зогсоох, тасалдах, дуусах) арга зүй нь иргэнлэг болон нийтлэг эрх зүйн уламжлал бүхий улсуудад ялгаатай байдлаар тодорхойлогдож ирсэн байна. Өөрөөр хэлбэл, хөөн хэлэлцэх хугацааны хязгаарыг тодорхойлох улс орнуудад харилцан адилгүй байна.

Уг сэдэвтэй холбогдуулан Англи-Саксоны эрх зүйн бүл болон Ром-Германы эрх зүйн бүлтэй улс орнууд болох ХБНГУ, БНФУ, Япон улс, АНУ, ИБУИНХУ гэх мэт улсуудын хөөн хэлэлцэх хугацааны талаар дэлгэрэнгүй судлан үзлээ.

Энэхүү судалгааны зорилго нь хөөн хэлэлцэх хугацааны ойлголтыг Англи-Саксоны эрх зүйн бүл болон Эх газрын эрх зүйн бүлтэй улс орнуудыг харьцуулан судалж, хөөн хэлэлцэх хугацааны тогтолцоо, түүний хэрэглээний талаар тухайн улс орны эрх зүйн орчинд хэрхэн тодорхойлогдож, хөгжиж ирснийг харуулах юм. Судалгааны үр дүнд, улс орнуудад хөөн хэлэлцэх хугацааг тодорхойлох, тоолох арга зүйн ялгаа, түүний эрх зүйн практик нь тухайн улс орны эрх зүйн системийн онцлог, түүх, соёлд хэрхэн нийцэж байгаа талаар гүнзгий ойлголт авч болох юм.

#### Abstract

The concept, essence, and objectives of the statute of limitations have been interpreted differently across jurisdictions belonging to the civil law and common law traditions. In other words, the scope and determination of limitation periods vary among countries.

In this regard, the present study undertakes a detailed comparative examination of the statute of limitations as regulated in representative jurisdictions of the Anglo-Saxon and Romano-Germanic legal families—namely, Germany, France, Japan, the United States, and the United Kingdom.

The primary objective of this research is to comparatively analyze the concept of the statute of limitations within the Anglo-Saxon and continental legal systems, and to elucidate how the structure,

<sup>1</sup> Дотоод хэргийн Их сургуулийн Тэнхимийн эрхлэгч, хууль зүйн доктор (Ph.D)

*function, and application of limitation periods have been defined and evolved within their respective legal frameworks.*

*The findings of this study provide deeper insight into how the methodologies for determining, calculating, suspending, interrupting, and terminating limitation periods reflect the distinctive characteristics, historical development, and cultural context of each national legal system.*

Энэ өгүүлэл [CC BY-NC](#) лицензийн дагуу нээлттэй хандалтын эрхтэй.



## 1. Танилцуулга

Хөөн хэлэлцэх хугацаа түүний эрх зүйн агуулга нь улс орнуудын эрх зүйн уламжлал, эрх зүйн системийн онцлогтой уялдаатайгаар өөр өөрөөр тодорхойлогддог. Хөөн хэлэлцэх хугацааг иргэнлэг эрх зүйн уламжлал бүхий цөөнгүй улс голчлон **материаллаг эрх зүйн хэм хэмжээ** гэж авч үздэг бөгөөд түүний эрх зүйн тодорхой байдал буюу хууль ёсны байдлыг хангах үүргийг чухалчлан үздэг. Тухайлбал Итали, Австри, Грек, Унгар, Польш (The Criminal Code z dnia 6 czerwca 1997 r. (Dz.U. tłum. Ю gb Nr 88, poz. 553), Chapter XI) зэрэг улс хөөн хэлэлцэх хугацааг материаллаг эрх зүйн асуудал гэж үздэг бөгөөд хөөн хэлэлцэх хугацааг хүчингүй болгох нь үндэслэлтэй төдийгүй шийтгэл оногдуулахад буцаан хэрэглэдэг гэж үздэг байна.

50

Үүний эсрэгээр, зарим эрх мэдлийн хүрээнд хөөн хэлэлцэх хугацааг **процессын эрх зүйн асуудал** гэж үздэг бөгөөд эн хандлагыг баримталж буй улсуудын хувьд цаг хугацаа өнгөрөхөд нотлох баримт алдагдахад хүргэдэг. Учир нь гэрчүүд үйл явдлыг хамгийн сайндаа хязгаарлагдмал хэмжээгээр санаж, бусад нотлох баримтыг олж авах боломжгүй байдаг учир нь хууль бусаар шийтгэгдэх, яллах аюул нэмэгдэнэ гэж үздэг. Мөн эд хөрөнгийн эрхийг хөндөхөөс илүүтэйгээр шүүхийн үйл ажиллагааг зохицуулах үүрэгт нь анхаардаг. ХБНГУ, БНФУ, БНЭнэтхэг зэрэг улсад хөөн хэлэлцэх хугацааг шүүх ажиллагаанд саад учруулдаг хэмээн процессын хуулийн хүрээнд тодорхойлж, процессын шинж чанарыг онцолсон байдаг.

Зарим улс материаллаг болон процессын аль алиных нь ангиллын элементийг хүлээн зөвшөөрч, холимог арга барилыг баримталдаг байна. Тухайлбал, Эстони, Испани, Швед зэрэг улс энэ хоёр үзэл хандлагын аль алийг дэмжсэн холимог шинжтэй байна. Эстони улсад зохиогчийн эрхийн хөөн хэлэлцэх хугацааг процессын эрх зүйн хүрээнд авч үздэг бол, Испани улсад зохиогчийн эрхийг цэвэр материаллаг эрх зүйн хүрээнд хөөн хэлэлцэх хугацааг авч үздэг.

## 2. Арга зүй

Энэхүү илтгэлээр хөөн хэлэлцэх хугацааг тодорхойлох, тоолох арга зүйн ялгаа, түүний улс орнуудад хэрхэн хэрэглэгдэж, хөгжиж буй талаар судлан авч үзлээ.

### 3. Судалгааны үр дүн

Хөөн хэлэлцэх хугацаа нь талуудын хооронд хууль ёсны тодорхой байдлыг бий болгож, маргаан, хариуцлагыг хязгаарлахад чиглэгддэг. Мөн эрх нь зөрчигдсөн талыг хариуцлагатай байх, эрхээ цаг хугацаанд нь эдлэхийг шаардахын зэрэгцээ хариуцагчийг хязгааргүй хүлээлтийн дарамтаас хамгаалах замаар нийгмийн тогтвортой байдлыг хангахад чухал үүрэг гүйцэтгэдэг.

Энэ эрх зүйн уламжлал бүхий улсууд төрийн бодлогын улмаас ихэнх иргэний үйлдлүүд нь тодорхой хугацаа өнгөрсний дараа хариуцагчийг тухайн үйлдлийнхээ дагуу шүүхэд өгөх боломжгүй болдог онцлогтой байдаг. Цаг хугацаа өнгөрөхөд нөхөн олговор олгох үйл ажиллагааг хориглохтой холбоотой хоёр өөр эрх зүйн дэглэм байдаг. Эхний дэглэм нь 1980 оны Хязгаарлалтын тухай хуульд тусгагдсан бөгөөд энэ нь янз бүрийн төрлийн үйл ажиллагааны хязгаарлалтын тодорхой хугацааг шууд заасан байдаг. Хоёр дахь дэглэм нь эргэн тойрны бүх нөхцөл байдлыг харгалзан тухайн хэргийн улмаас шударга ёсны дагуу арга хэмжээ авах хугацааг хязгаарласан эсэхийг тодорхойлдог laches-ийг шударгаар хамгаалах явдал юм. (Graham Virgo, 2006) *laches*<sup>2</sup> нь тодорхой нөхцөлд хөөн хэлэлцэх хугацааг түр зогсоож болох үндэслэл мөн бөгөөд шүүгч шударга байдлыг хангах, хууль ёсны хамгаалалтыг хэрэгжүүлэхийн тулд тэгш эрхийн үүднээс хөөн хэлэлцэх хугацааг түр зогсоох явдал мөн.

Хөөн хэлэлцэх хугацаа нь талуудын хооронд хууль ёсны тодорхой байдлыг бий болгож, маргаан, хариуцлагыг хязгаарлахад чиглэгддэг. Энэ нь нийгмийн тогтвортой байдлыг хангахад чухал үүрэг гүйцэтгэдэг.

**Эрх зүйн бүлийн хувьд харьцуулан үзвэл** Англи-Саксоны эрх зүйн бүл бүхий орнуудад хөөн хэлэлцэх хугацааны ойлголт бараг байдаггүй бөгөөд зөвхөн зарим төрлийн хөнгөн гэмт хэрэгт хөөн хэлэлцэх хугацааг хэрэглэдэг онцлогтой. Харин хөөн хэлэлцэх хугацааны ойлголтыг Эх газрын буюу Ром-Германы эрх зүйн бүл бүхий орнуудад гол төлөв хэрэглэдэг байна. Тэр дундаа эрүүгийн эрх зүй дэх хөөн хэлэлцэх хугацаа тооцох арга зүйн асуудал нь нэлээд маргаантай байдаг.

Энэ нь гэмт хэргийг үйлдсэн тэр л цаг хугацаанд нь түүнд тохирсон хариуцлага ногдуулах ёстой, эсхүл гэмт хэргийн нийгмийн хор аюул хэзээ ч алба болдоггүй гэсэн эсрэг тэсрэг байр суурь, хандлагын зөрүүгээс үүсдэг. Нөгөө талаар аливаа үйлдлийг эрүүлжүүлэх нийгмийн үзэл хандлага, гэмт хэргийн объектив талын шинжийн хувьсал, тэр дундаа үйлдлийн арга хувьсан өөрчлөгдөж буй байдал зэрэг нь гэмт хэргийн талаарх нийгмийн үзэл хандлагад өөрчлөлт бий болгож, аливаа үйлдлийг гэмт хэрэгт тооцох материаллаг болон процессын эрх зүй хувьсан өөрчлөгдөж ирсэн байна.

Эрх зүйн бүлийн хувьд ялгаатай улсууд хөөн хэлэлцэх хугацаа тогтоож буй онолын үндэслэлийг харьцуулсан байдлыг нэгтгэн харуулбал:

*Хүснэгт №1. Эрх зүйн бүлийн хувьд ялгаатай улсууд хөөн хэлэлцэх хугацаа тогтоож буй онолын үндэслэлийг харьцуулсан байдал*

<sup>2</sup> (/ˈlætʃɪz/ LAT-chiz, /ˈleɪ-/; Хуулийн франц хэлээр: санамсаргүй байдал, өргөсөх, хуучин франц хэлнээс: lachesse) нь хууль ёсны нэхэмжлэл гаргах, эрхээ хууль ёсны дагуу хэрэгжүүлэхэд эрх тэгш байдлыг хамгаалах явдал юм. Үүнийг ихэвчлэн хөөн хэлэлцэх хугацаа, хууль ёсны хамгаалалттай харьцуулж ойлгодог.

Асуудал	Эх газрын эрх зүйн бүл	Англо-Саксоны эрх зүйн бүл
Хууль тогтоомжийн шинж	Нарийвчилсан зохицуулалттай, кодчилсон	Уян хатан, шүүхийн тайлбар, шийдвэрт тулгуурлана.
Уян хатан байдал	Хуульд заасан хугацааг чанд мөрддөг	Шүүх эрх мэдлийн хүрээнд хугацааг сунгаж болно.
Хугацааг түдгэлзүүлэх ба тасрах	Тодорхой зааг ялгаатай	"Tolling" механизмаар нэгдмэл байдлаар авч үздэг.
Хугацааны урт	Ерөнхийдөө урт байдаг (5-30 жил)	Төрлөөс хамааран хувьсамтгай байна.

Хөөн хэлэлцэх хугацаа тогтоож буй арга зүйн асуудлыг харьцуулан үзвэл:

1. хөөн хэлэлцэх хугацааг объектив болон субъектив шалгуураар тогтоож байгаа;
2. хөөн хэлэлцэх хугацаатай холбоотой зохицуулалтыг материаллаг /нийт хугацааг тогтоосон/ болон процессын /хугацааг хэрэглэх журам тогтоосон/ шинжтэй гэж ялгамжтай авч үздэг;
3. хөөн хэлэлцэх хугацааг гэмт хэргийн ангилал, оногдуулж болох ялын төрөл, түүний интервал, эсхүл эдгээрийн аль алийг нь хослуулж шалгуур болгох замаар тогтоож байгаа;
4. хөөн хэлэлцэх хугацааг гэмт хэрэг, зөрчлийн нийгмийн хор аюулыг шалгуур болгон хэрэг тус бүрээр тогтоох болсон зэрэг ялгамжтай байдлаар хөөн хэлэлцэх хугацааг тогтоож байна.

52

Энэ нь нэг талаас тухайн улсын эрх зүйн уламжлал болон эрх зүйн бүлээс хамаарч болох ч нөгөө талаас эрх зүйн үнэт зүйлийн хувьсал, хөгжлийн чиг хандлага, хөөн хэлэлцэх хугацааны мөн чанар, үзэл баримтлал, зорилгоос хамааралтай.

Улс орнуудын ялгаатай эрх зүйн зохицуулалтын онолын үндэслэл, практикийг харьцуулан судалж, тэдний нийтлэг болон өвөрмөц байдал, өөр хоорондын уялдаа, харилцан хамаарлыг тодорхойлох, дүн шинжилгээ хийх зорилтын хүрээнд эрх зүйн бүлийн онцлог, ижил төстэй байдал, эрх зүйг хөгжлийн түвшин зэргийг харгалзан **ХБНГУ, БНФУ, Япон улс, АНУ, ИБУИНХУ**-ыг сонгон авч онолын үндэслэл болон эрх зүйн зохицуулалтынх нь хувьд харьцуулан үзлээ.

Эдгээрээс иргэнлэг эрх зүйн уламжлал бүхий Франц, Герман, Япон зэрэг улс хөөн хэлэлцэх хугацааг ижил төрлийн нэхэмжлэлийн дагуу кодолсон хуульд үндэслэн хууль тогтоомжийг чанд баримтлан тодорхой хугацаа өнгөрсний дараа нэхэмжлэл гаргах эрхэд хязгаарлалт тогтоодог бөгөөд онол, арга зүйн хувьд харьцангуй жигд байна.

Дээрх хөөн хэлэлцэх хугацаа тогтоож буй арга зүйн ялгамжтай байдал нь түүнийг тоолох, түр зогсоох буюу түдгэлзүүлэх, тасалдах үндэслэлийг өөр өөрөөр тодорхойлоход хүргэдэг байна. Тухайлбал,

**ХБНГУ.** Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын эрх зүйн бүл нь "Civil Law" буюу иргэнлэг эрх зүйн уламжлалд суурилсан бөгөөд Ромын эрх зүйн уламжлал дээр үндэслэгдсэн.

Германы эрх зүйн тогтолцоо нь формализм буюу тодорхой дүрэм, журмыг чанд мөрдөх шинжтэй бөгөөд шийдвэрүүдийг өргөн хэрэглээнд хэрэгжүүлэхэд чиглэгддэг. Түүнчлэн Германы хуулиуд нь зөвхөн бичгийн хууль биш, урт хугацаанд боловсронгуй болж ирсэн онолын үндсийг мөн агуулдаг. Германы эрүүгийн хууль нь гүнзгий онолын үндэслэл, хүнд сурталгүй, шуурхай шийдвэрлэх механизмтай.

ХБНГУ-ын Эрүүгийн хууль (*Strafgesetzbuch, StGB*)-ийн 78 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт: "хөөн хэлэлцэх хугацаа (*Verjährungsfrist*) нь эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг дуусгавар болгож, албадлагын арга хэмжээ хэрэглэхгүй байх үндэслэл болно" гэж нийтлэг байдлаар тодорхойлсон ч 2 дахь хэсэгт "хүндрүүлэх нөхцөл байдалтайгаар хүнийг алах гэмт хэрэгт хөөн хэлэлцэх хугацааг тоолохгүй" гэжээ. (Өмирбек, 2023)

Хуулийн 78 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт гэмт хэргийн хүндрэлийн зэрэг, оноох ялын хэмжээнээс хамааруулан хөөн хэлэлцэх ерөнхий хугацааг дараах байдлаар ялгаатай тогтоосон байна: (Өмирбек, 2023)

- Бүх насаар нь хорих ял оногдуулахаар заасан гэмт хэрэг үйлдсэн бол 30 жил;
- 10-аас дээш жил хорих ял оногдуулах гэмт хэрэг үйлдсэн бол 20 жил;
- 5-10 жил хүртэл хугацаагаар хорих ял оногдуулах гэмт хэрэг үйлдсэн бол 10 жил;
- 1-5 жил хүртэл хугацаагаар хорих ял оногдуулах гэмт хэрэг үйлдсэн бол 5 жил;
- Бусад гэмт хэрэгт 3 жил. (Өмирбек, 2023; Өмирбек, 2023)

ХБНГУ-ын Эрүүгийн хуулийн 78 дугаар зүйлд хөөн хэлэлцэх хугацааг гэмт үйлдэл төгссөн хугацаанаас (үргэлжилсэн үйлдэлтэй буюу давтан гэмт хэрэг үйлдсэн бол сүүлийн гэмт үйлдлээс) эхэлж тоолохоор заасан боловч тодорхой нөхцөлд (жишээлбэл, хохирогч нь насанд хүрээгүй байх үед) хугацааг тоолох эхлэл нь өөрчлөгдөж болно. Мөн гэмт хэргийн хор уршгийг гэмт хэргийн бүрэлдэхүүнд хамааруулсан тохиолдолд хөөн хэлэлцэх хугацааг хор уршиг илэрсэн өдрөөс эхлэн тоолохоор, 78 дугаар зүйлд гэмт хэрэг үйлдсэн үеэс эхлэн тодорхой хугацаа өнгөрөх хүртэл хөөн хэлэлцэх хугацааг тоолохыг зогсоож, хуульд заасан хугацаанаас эхлэн шинээр тоолохоор зохицуулсан байна. (Өмирбек, 2023)

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг эхлүүлснээр хөөн хэлэлцэх хугацааг тоолохгүй байх буюу хязгаартайгаар тоолох (Өмирбек, 2023) ойлголт улс орон бүрийн Эрүүгийн хууль тогтоомжид өөр өөр онцлогтойгоор зохицуулагдсан. Үүнд:

ХБНГУ-д гэмт хэрэг үйлдсэн этгээдтэй холбоотой аливаа процессын шинжтэй үйл ажиллагаа (*гэмт хэрэгт холбогдох этгээдийг сэжигтнээр бүртгэх, мөрдөн шалгах ажиллагаа эхлүүлэх, гэмт хэргийн талаарх шийдвэр гаргах үйл явц эхлэх, шүүхээс шийдвэр гаргах эсвэл шүүх хурал товлох г.м*) эхлүүлснээр хөөн хэлэлцэх хугацааг тасалж, цаашид тоолохгүй байхаар хуульчилсан бөгөөд тасралтын дараа хөөн хэлэлцэх хугацааг шинээр тоолдог байна.<sup>3</sup> (Өмирбек, 2023)

<sup>3</sup> Энэ талаар Болгар улсад эрх бүхий байгууллага тодорхой этгээдэд холбогдуулан мөрдөн шалгах ажиллагааг эхлүүлснээр, Гүрж улсад ялагдагчаар татсанаар, Испанид эрүүгийн хэрэг үүсгэснээр, Латви улсад ялах дүгнэлт үйлдсэнээр, Нидерланд улсад гэмт хэргийн талаар мөрдөн шалгах эрх бүхий байгууллагад гэмт хэргийн талаарх мэдээлэл гаргаснаар тасрахаар заасан байдаг байна. Харин

Мөн гэмт хэрэг үйлдсэн этгээд гадаадад байх, Үндсэн хуулийн эсрэг гэмт хэрэг үйлдсэн тохиолдолд мөрдөн шалгах ажиллагаа хэрэгжүүлэх боломж хязгаарлагдмал байх, дайн эсвэл онц байдал зарласан зэрэг тусгай нөхцөлд хөөн хэлэлцэх хугацааг түр зогсоох буюу түдгэлзүүлэхээр заасан байна.

ХБНГУ-ын Эрүүгийн хуульд тодорхой төрлийн тухайлбал, хүн амины хэрэг геноцид болон хүн төрөлхтний эсрэг гэмт хэрэг, дайнтай холбоотой гэмт хэрэгт хөөн хэлэлцэх хугацаагүй байхаар заасан байна.

ХБНГУ-ын Иргэний хууль (Bürgerliches Gesetzbuch, BGB) (htt3) нь иргэний эрх зүйн харилцаанд хөөн хэлэлцэх хугацааг (Verjährung) нарийвчлан зохицуулж, гэрээ, үүрэг, нэхэмжлэлийн эрх зүйн үр дагаврыг тодорхойлсон зохицуулалтыг агуулдаг. Тус хуульд зааснаар ерөнхий хөөн хэлэлцэх хугацаа нь 3 жил байх бөгөөд энэ хугацааг нэхэмжлэл гаргах эрх үүссэнээс хойш тоолдог. Зарим онцгой тохиолдолд (жишээлбэл, үл хөдлөх хөрөнгийн өмчтэй холбоотой маргаан) 10-30 жил, тэр дундаа үндсэн эрх, өмчийн эрхтэй холбоотой тодорхой нэхэмжлэлд 30 жилийн хөөн хэлэлцэх хугацааг тогтоосон нь онцлогтой байна.

Хөөн хэлэлцэх хугацааг тухайн эрх зөрчигдсөн эсвэл нэхэмжлэл гаргах боломж үүссэн өдрөөс эхлэн тоолдог. Гэсэн хэдий ч хохирогч тухайн эрх зөрчигдсөн талаар мэдээгүй тохиолдолд хугацаа зөрчлийг мэдсэн өдрөөс эхэлдэг. Хуульд заасан тодорхой нөхцөлд (Гэрээний маргааныг эвлэрүүлэн шийдвэрлэх хэлэлцээ хийх үед, өрийг хүлээн зөвшөөрсөн эсвэл шийдвэрлэх боломжгүй нөхцөлд, дайн, байгалийн гамшиг зэрэг шалтгаанаар талууд эрхээ хэрэгжүүлэх боломжгүй тохиолдолд г.м) хөөн хэлэлцэх хугацаа түдгэлздэг.

ХБНГУ-ын Иргэний хуульд нэхэмжлэл гаргах, шүүхийн процесс эхлэх, өрийг хүлээн зөвшөөрөх тохиолдолд хөөн хэлэлцэх хугацааг таслахаар заасан бөгөөд ийнхүү тасалсан тохиолдолд тухайн үеэс эхлэн хугацааг шинээр тоолно. Зарим төрлийн иргэний нэхэмжлэл, тухайлбал, хүүхдийн эцэг, эхийн харилцаатай холбоотой үндсэн эрх зөрчигдөх асуудалд хөөн хэлэлцэх хугацаагүй гэж заасан байдаг.

ХБНГУ-ын Иргэний хууль дахь хөөн хэлэлцэх хугацааны зохицуулалт нь 3 жилийн ерөнхий хугацаатай боловч, бүхэлдээ хугацааг түдгэлзүүлэх болон таслах нөхцөлийг нарийвчлан тодорхойлсон, хохирогч эрхээ мэдсэн эсвэл мэдэх боломжтой үеэс хугацаа эхлэх уян хатан зохицуулалттай, эрх зүйн тогтвортой байдал, эдийн засгийн эргэлт, шударга шүүхийн зарчмыг хангах чиглэлээр оновчтой шийдлийг агуулсан байна.

**Бүгд Найрамдах Франц Улс (БНФУ).** Францын эрх зүйн тогтолцоо нь Ромын эрх зүйн тогтолцооны үндэс дээр бүтээгдсэн. Францын эрүүгийн хуульд (Code pénal) гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацаа нь эрүүгийн хариуцлагаас чөлөөлөх, гэмт хэрэгт холбогдсон этгээдийг хууль ёсны хариуцлагад татах хугацааны хязгаарлалт байдлаар тусгагдсан байдаг. Энэхүү зохицуулалт нь хүний эрхийг хамгаалах, шүүхийн үйл ажиллагааны үр дүнг баталгаажуулах, нотлох баримтыг цаг хугацааны явцад алдагдахаас сэргийлэх зорилготой.

---

*Австри зэрэг зарим оронд эрүүгийн хэргийг шүүхэд хянан шийдвэрлэх шатанд хөөн хэлэлцэх хугацаа тасардаггүй бол Испани, Норвег зэрэг улс оронд эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх бүх шатанд хөөн хэлэлцэх хугацаа тасрах ёсгүй гэж хуульчилсан байдаг.*

Франц улсын эрүүгийн хуулиар гэмт хэргийн шинж чанар, хүндрэлийн түвшингээс хамааран дараах байдлаар тогтоосон байна:

- Онц хүнд гэмт хэрэг (*Crimes*)-т 10-20 жил (хүн амины хэрэг, онц ноцтой хүчирхийлэл

- Хүндэвтэр гэмт хэрэг (*Délits*)-т 3-6 жил (залилах, хулгайлах, санхүүгийн гэмт хэрэг)

- Хөнгөн гэмт хэрэг (*Contraventions*)-т 1 жил (замын хөдөлгөөний дүрэм зөрчих)

Хөөн хэлэлцэх хугацаа гэмт хэрэг үйлдэгдсэн өдрөөс эхлэх ерөнхий зохицуулалттай боловч тодорхой нөхцөлд хугацааг өөрөөр эхлүүлэх зохицуулалттай. Тухайлбал, нуугдмал гэмт хэрэгт хөөн хугацааг хохирогч гэмт хэргийг мэдсэн өдрөөс, хүүхдийн эсрэг хүчирхийллийн хэргүүдэд хохирогч насанд хүрсэн өдрөөс хугацааг тоолох зохицуулалттай байна.

Гэмт хэрэгтэн оргон зайлсан, шүүхийн болон мөрдөн байцаалтын үйл явц саатсан тохиолдолд хөөн хэлэлцэх хугацааг дараах нөхцөлд түдгэлзүүлдэг бөгөөд гэмт хэрэгтэнтэй холбоотой ямар нэгэн процесс эхэлсэн үед хөөн хэлэлцэх хугацааг тасалж, шинээр тоолох зохицуулалттай.

Геноцид, хүн төрөлхтний эсрэг гэмт хэрэгт хөөн хэлэлцэх хугацаа үйлчлэхгүй. Энэ нь хүний эрхийг хамгаалах олон улсын жишигтэй нийцдэг.

Франц Улсын Иргэний хуулийн (*Civil Code of French Republic, 2013*) хөөн хэлэлцэх хугацааны зохицуулалт нь эрх зүйн харилцааны тогтвортой байдлыг хангах, нотлох баримтын чанарыг алдагдахаас сэргийлэх, шударга ёсыг баталгаажуулахад чиглэсэн. Энэ нь талуудын эрхийг хамгаалахад онцгой үүрэгтэй эрх зүйн зохицуулалт юм.

Францын Иргэний хуулийн 2008 оны шинэчлэлийн дагуу иргэний хэргийн ерөнхий хөөн хэлэлцэх хугацааг 30 жилээс 5 жил болгон тогтоосон байна. Энэ хугацаа нь нэхэмжлэгч өөрийн эрх зөрчигдсэнийг мэдсэн өдрөөс эхэлнэ. Зарим төрлийн нэхэмжлэл (*гэрээний маргаан 5 жил, гэм хорын нөхөн төлбөр хохирлыг мэдсэн өдрөөс эхэлнэ 10 жил, өмчлөх эрхийн маргаан 30 жил, өв залгамжлал өвлөгч эрхээ мэдсэнээс хойш 5 жил*)-д хөөн хэлэлцэх хугацааг тусгайлан заасан байдаг.

Нэхэмжлэгч насанд хүрээгүй эсвэл сэтгэцийн чадамжгүй байх, онцгой нөхцөл (байгалийн гамшиг, дайн)-ийн үед хөөн хэлэлцэх хугацааг түдгэлзүүлдэг бөгөөд хариуцагч өр төлбөрөө хүлээн зөвшөөрөх, нэхэмжлэгч шүүхэд нэхэмжлэл гаргасан тохиолдолд хөөн хэлэлцэх хугацаа тасарч, шинээр эхэлдэг байна.

Франц улсын иргэний хэргийн хөөн хэлэлцэх хугацааны зохицуулалт нь хууль ёсны тогтвортой байдлыг хангах, иргэдийн эрхийг хамгаалахад чиглэсэн оновчтой тогтолцоо юм. 2008 оны шинэчлэл нь хөөн хэлэлцэх хугацааг богиносгосноор эрх зүйн тодорхой байдлыг нэмэгдүүлж, олон улсын жишигт нийцүүлсэн. Францын энэ зохицуулалт нь зөвхөн шүүхийн үр ашигт байдлыг нэмэгдүүлэхээс гадна эдийн засгийн харилцааны итгэлцлийг баталгаажуулахад чухал ач холбогдолтой болсныг судлаачид онцолсон байна. (*Civil Code of French Republic (excerpts related to citizenship), 2013*)

**Япон улс.** Япон улсын эрх зүйн бүл нь Европын болон Америкийн эрх зүйн тогтолцооны нөлөөгөөр бүрэлдэн тогтсон бөгөөд "Civil Law" буюу иргэнлэг эрх зүйн уламжлалд суурилсан байдаг. Энэ нь Ромын эрх зүйн уламжлалаас гаралтай бөгөөд Япон

улс нь 19 дүгээр зууны үеэс Европын эрх зүйн тогтолцоог өөрийн орны онцлогт нийцүүлэн хөгжүүлжээ.

Японы иргэний болон эрүүгийн хуулиуд нь хөөн хэлэлцэх хугацаа (時効, Jikō)-г чухал ач холбогдолтой гэж үздэг. Японы эрүүгийн хуульд гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацаа нь тухайн гэмт хэргийн төрлөөс хамаардаг бөгөөд энэ нь гэмт этгээдийн хариуцлага хүлээх хугацааг дуусгахгүй байх, шүүхээр шийдвэрлэхээс өмнө хөөн хэлэлцэх хугацааг таслах болон эхлүүлэх боломжтой байдаг.

Япон улсын Эрүүгийн хуулиар гэмт хэргийн хүндрэлийн түвшинг харгалзан амиа хорлох гэмт хэрэгт 25 жил (2010 оноос өмнө хугацаагүй байсан), хүнд гэмт хэрэгт 15-20 жил (хүн амины хэрэг, хүнд гэм хор учруулах гэх мэт), хөнгөн гэмт хэрэгт 3-10 жил (хулгай, залилах гэх мэт) байхаар тогтоосон.

Хөөн хэлэлцэх хугацаа нь ерөнхийдөө гэмт хэрэг үйлдэгдсэн өдрөөс эхэлдэг. Гэхдээ зарим гэмт хэргийн хувьд (жишээ нь, хохирогч гэмт хэргийг шууд мэдэх боломжгүй нөхцөлд), тухайн гэмт хэргийг мэдсэн үеэс хугацааг эхэлж тоолно.

Гэмт хэрэгт холбогдсон этгээдэд холбоотой аливаа процесс эхлэх үед хөөн хэлэлцэх хугацааг тасалж, шинээр тоолж эхэлдэг.

2020 оны 4 сарын 1-нд хэрэгжиж эхэлсэн Япон улсын Иргэний хуулийн шинэчлэлд хөөн хэлэлцэх хугацааг дараах байдлаар тогтоожээ:

- Ерөнхий хугацаа: Иргэний хэргийн хувьд хөөн хэлэлцэх хугацаа 5 жил;
- Гэрээний маргаан: Хоёр талын гэрээгээр хүлээн зөвшөөрөгдсөн үүргийн хувьд 5 жил;
- Энгийн нэхэмжлэл: Иргэний эрх зөрчигдсөнөөс хойш 10 жилийн дотор нэхэмжлэл гаргах эрхтэй.

Нэхэмжлэгч өөрийн эрх зөрчигдсөнийг мэдсэн өдрөөс эхлэн хөөн хэлэлцэх хугацааг тооцно. Хэрэв нэхэмжлэгч эрхийн зөрчлийг мэдээгүй байсан бол зөрчил гарсан өдрөөс эхлэн 10 жилийн хязгаарлалт тавигдана.

Байгалийн гамшиг, дайн зэрэг тодорхой хүчин зүйлийн улмаас нэхэмжлэгч нэхэмжлэл гаргах боломжгүй байх, хариуцагчийн нас барсан тохиолдолд өв залгамжлагчид хугацааг сунгах боломж олгох, нэхэмжлэгч нь насанд хүрээгүй эсвэл сэтгэцийн чадамжгүй байх тохиолдолд хөөн хэлэлцэх хугацааг түдгэлзүүлдэг:

Хариуцагч өрийг хүлээн зөвшөөрөх, эсвэл шүүхэд хандах үйлдэл хийх тохиолдолд хөөн хэлэлцэх хугацаа тасалж, шинээр эхэлнэ.

Иргэний хэргийн нэхэмжлэлийн төрлөөс хамааран хөөн хэлэлцэх хугацаа харилцан адилгүй байна. Үүнд:

- Гэрээний үүрэг: 5 жил.
- Хувийн гэм хор: 3 жил (хохирлыг мэдсэн өдрөөс).
- Үл хөдлөх хөрөнгөтэй холбоотой: 10 жил.
- Өв залгамжлал: Өв залгамжлах эрхээ мэдсэнээс хойш 3 жил.

**Америкийн нэгдсэн улс.** АНУ-ын эрх зүйн бүл нь эрх зүйн тогтолцооны хувьд "Common Law" буюу нийтлэг эрх зүйд суурилсан байдаг. Шүүхийн шийдвэрүүд нь прецедент (*prior case law*) болдог бөгөөд дараагийн шүүх хэргүүдэд чухал үүрэг гүйцэтгэдэг. Прецедент нь хууль зүйн шийдвэр гаргахад нь шүүхүүдэд чухал зөвлөмж болдог. АНУ нь Холбооны улс бөгөөд төрийн эрх мэдэл нь холбооны засаг болон тухайн

мужийн засгийн газар хооронд хуваарилагдсан байдаг. Энэ бүтэц нь АНУ-ын эрх зүйн системд онцгой нөлөө үзүүлдэг.

АНУ-ын эрх зүйн систем нь нийтлэг эрх зүй (*Common Law*)-н уламжлалд суурилсан бөгөөд шүүхийн шийдвэрүүд (*Case law*) нь хуулийн зөвлөмж, үүрэг даалгавар болгон ажилладаг. Гиймээс, шүүхийн шийдвэрүүд нь хуулийн чухал хэсэг болж, хуульчид эдгээр шийдвэрийг зөвшөөрч, хэрэглэх замаар хуулийн амьд практикийг бий болгодог.

АНУ-ын гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацаа нь бүхэлдээ шударга ёс, эрх зүйн тодорхой байдал, нийгмийн ашиг сонирхлыг хангах онолд үндэслэдэг бөгөөд гэмт хэргийн төрөл, онцлог, хүндрэлийн зэргээр ялгаатай тогтоогддог. Хөөн хэлэлцэх хугацааг холбооны болон мужийн хуулиудаар зохицуулагддаг.

Холбооны хуульд зааснаар хүнд гэмт хэрэг (*Felonies*) ихэвчлэн 5-10 жил, хөнгөн гэмт хэрэг (*Misdemeanors*) ихэвчлэн 1-2 жилийн хөөн хэлэлцэх хугацаатай.

Гэхдээ онц хүнд гэмт хэрэг, тухайлбал, хүн амины хэрэг, геноцид, хүн төрөлхтний эсрэг гэмт хэрэг, хүүхдийн эсрэг бэлгийн хүчирхийлэл (зарим мужуудад), террорист үйл ажиллагаа зэрэгт хөөн хэлэлцэх хугацаа байхгүй.

Хөөн хэлэлцэх хугацааг ерөнхийдөө гэмт хэрэг үйлдэгдсэн өдрөөс эхлэн тоолно. Гэвч зарим тохиолдолд хохирогч гэмт хэргийг мэдсэн эсвэл мэдэх боломжтой болсон өдрөөс тоолдог. Энэ нь ялангуяа санхүүгийн залилан эсвэл бэлгийн хүчирхийллийн гэмт хэргүүдэд хамаардаг байна.

Гэмт хэрэгтэн гадаад улсад оргон зайлсан, хохирогч нь насанд хүрээгүй, сэтгэцийн хувьд чадамжгүй байсан, хууль зүйн саад тотгор үүссэн зэрэг нөхцөлд хөөн хэлэлцэх хугацааг түр түдгэлзүүлж болно.

Холбогдох этгээдийг баривчлах, мөрдөн шалгах ажиллагаа эхлүүлэх зэрэг үйл ажиллагаа явуулснаар хөөн хэлэлцэх хугацааг тасалж, шинэ хугацааг эхлүүлэх боломжтой.

АНУ-д олон мужид хүн амины хэргийн хөөн хэлэлцэх хугацаа байдаггүй. Зарим муж харьяаллаас хамааран бэлгийн хүчирхийллийн гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацааг хасдаг.

АНУ-ын хөөн хэлэлцэх хугацааны зохицуулалт нь Европын орнуудаас илүү уян хатан, нөхцөл байдалд суурилсан байдаг. Ялангуяа хохирогчийн эрхийг хамгаалахад ихээхэн ач холбогдол өгдөг бөгөөд хохирогч гэмт хэргийг мэдэх боломжтой болсон үеэс хугацаа тоологддог зохицуулалт нь онцлог юм.

АНУ-ын Иргэний хэрэгт хөөн хэлэлцэх хугацаа тогтоох байдал нь мужууд болон нэхэмжлэлийн төрлөөр ихээхэн ялгаатай байдаг.

Иргэний хуулийн маргаанд хамаарах хугацаа нь нэхэмжлэлийн төрлөөс хамааран өөрчлөгддөг. Тухайлбал,

- Гэрээний маргаан: Ерөнхийдөө 3-6 жил.
- Хувийн гэм хор: Ихэнх мужид 2-3 жил.
- Үл хөдлөх хөрөнгөтэй холбоотой асуудал: 5-10 жил.
- Өв залгамжлал, гэрээслэлтэй холбоотой асуудал: 1-3 жил
- Холбооны ажил олгогчдод холбогдох маргаанд хөөн хэлэлцэх хугацаа 2 жил.
- Санхүүгийн залилангийн маргаанд 5 жилийн хугацаа тогтоогдсон.

Хөөн хэлэлцэх хугацаа нь нэхэмжлэгч тухайн эрх зөрчигдсөнийг мэдсэн эсвэл мэдэх боломжтой болсон өдрөөс эхлэн тоологдох бөгөөд хууль заасан зарим нөхцөлд хөөн хэлэлцэх хугацааг түр түдгэлзүүлнэ.

Холбогдох этгээд өрийг хүлээн зөвшөөрөх, маргаантай асуудалд эвлэрэл хийх оролдлого эхлэх, эсвэл шүүхийн процесс эхлэх тохиолдолд хөөн хэлэлцэх хугацаа тасалж, шинээр эхэлдэг.

АНУ-ын иргэний хэргийн хөөн хэлэлцэх хугацаа нь Европын эрх зүйн системтэй харьцуулахад илүү уян хатан бөгөөд нөхцөл байдлыг харгалзан хугацааг түдгэлзүүлэх, таслах зохицуулалтаараа онцлогтой. Ялангуяа хохирогчийн эрхийг хамгаалах чиглэлд ихээхэн ач холбогдол өгч, хугацааг тоолох эхлэлийн үеийг нэхэмжлэгчийн эрх мэдэх боломжтой болсон үеэс эхлүүлэх зохицуулалт нь онцгой давуу талтай.

**Их Британи, Умард Ирландын Нэгдсэн Хаант Улс (ИБУИНХУ).** Их Британийн эрх зүйн тогтолцоо нь нийтлэг эрх зүйн бүлд хамаарах тул хөөн хэлэлцэх хугацааны зохицуулалт нь онцлогтой. Ихэнх эрүүгийн хэргийн хувьд хөөн хэлэлцэх хугацаа тогтоохгүй байх зарчим баримталдаг нь бусад улс орнуудын зохицуулалтаас ялгаатай. Энэ нь ноцтой гэмт хэрэг үйлдсэн этгээдэд хариуцлагаас зайлсхийх боломж олгохгүй байхыг эрхэмлэсэн зарчимтай уялдана.

Их Британид гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацаа гэмт хэрэг үйлдэгдсэн өдрөөс эхлэх бөгөөд гэмт хэргийн төрлөөс хамааран хөөн хэлэлцэх хугацааны зохицуулалт харилцан адилгүй байна. Үүнд: Хөнгөн гэмт хэргийн хувьд 6 сар, хүнд (Indictable offences) болон онц хүнд гэмт хэрэгт хөөн хэлэлцэх хугацаа тогтоохгүй.

Зарим гэмт хэргийг (Hybrid offences) хөнгөн эсвэл хүнд байдлаар ангилж ял оноох боломжтой. Шүүх хэргийн хүндрэлийг тодорхойлсны дараа хөөн хэлэлцэх хугацаа хэрэгжих эсэхийг шийддэг. Нууцлагдмал гэмт хэргийг илэрсэн өдрөөс эхлэн тоолдог. Геноцид болон хүн төрөлхтний эсрэг гэмт хэрэг, хүүхдийн эсрэг бэлгийн дарамттай холбоотой хэргүүдэд хөөн хэлэлцэх хугацаа үйлчлэхгүй бөгөөд насанд хүрээгүй хохирогчид насанд хүрсний дараа ч нэхэмжлэл гаргах эрхтэй.

Хөөн хэлэлцэх хугацаа нь ихэвчлэн гэмт хэргийг илрүүлж, нотлох баримтыг олсон өдрөөс эхэлнэ.

Их Британид хүнд гэмт хэргүүдэд хөөн хэлэлцэх хугацаа тогтоохгүй байх нь Европын бусад орны эрх зүйн зохицуулалтаас ялгаатай. Их Британийн гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацааны зохицуулалт нь нийтлэг эрх зүйн системд тулгуурласан бөгөөд хүнд болон онц хүнд гэмт хэргүүдэд хугацаа тогтоохгүй байх зарчим баримталдаг. Энэ нь нийгмийн аюулгүй байдлыг хангах, хохирогчдын эрхийг хамгаалах, шударга ёсыг хэрэгжүүлэхэд чиглэсэн чухал зохицуулалт юм. Тус улсын энэхүү хандлага нь гэмт хэргийн хариуцлагаас зайлсхийх боломжийг хааж, гэм бурууг цаг хугацаанаас үл хамааран шийдвэрлэх үндэс суурийг бий болгодог.

Их Британи улсын иргэний хэргийн хөөн хэлэлцэх хугацааны зохицуулалт нь олон улсын эрх зүйн системийн хүрээнд онцлог бөгөөд энэ нь түүхэн болон практик үндсээрээ төлөвшсөн. Иргэний хэргийн хөөн хэлэлцэх хугацааг зохицуулахдаа "Шударга ёс", "Нийгмийн итгэлцэл" болон "Баримт нотолгооны чанар" гэсэн онолын үндэслэлүүдийг баримталдаг. Их Британи улсын хөөн хэлэлцэх хугацаа нь тодорхой эрх

зүйн хүрээнд хүчтэй хяналттай байдаг бөгөөд иргэний хэргүүдэд хязгаарлагдмал хугацааг тогтоох замаар эдгээр зорилтыг хангаж байна.

Их Британи улсад иргэний хэргийн хөөн хэлэлцэх хугацааны зохицуулалт нь 1980 оны Хязгаарлалтын тухай хууль (Limitation Act, 1980)-иар тодорхойлогддог бөгөөд энэ хуулиар иргэний хэргийн хөөн хэлэлцэх хугацааг тогтоох, хэрэглэх зарчим тодорхой хязгаартай байдаг. Иргэний хэргүүдэд ерөнхий хөөн хэлэлцэх хугацаа нь 6 жил байна. Энэ нь уг хэрэгт нэхэмжлэгч гаргасан шаардлагыг шүүх шийдвэрлэхэд хугацаа тогтоож, нэхэмжлэгчийг хурдан шийдвэр гаргуулахыг шаарддаг. (htt4) Үйлдлийн хувьд энэ хугацаа 12 жил хүртэл үргэлжилнэ.

Зөрчлийн нэхэмжлэл: Зөрчлийн, түүний дотор хайхрамжгүй хандсан үйлдлийг ихэвчлэн 6 жилийн дотор эхлүүлэх ёстой. (Anthony Bradley, 2011)

Гэхдээ бодит хохиролтой хэрэг (Personal injury claims) буюу гэмтэл, бэртэл гарсан бол хөөн хэлэлцэх хугацаа гэмтэл авсан өдрөөс 3 жилийн дотор эхэлдэг онцлогтой. Хэрвээ гэмт хэрэг нь илрээгүй тохиолдолд, хөөн хэлэлцэх хугацаа нь гэмт хэргийн илрэлээс хойш эхэлнэ.

Иргэний хэргийн хөөн хэлэлцэх хугацаа нь ямар ч нөхцөлд 15 жилээс илүү байж болохгүй. Хэрэг шүүхээр хянан шийдвэрлэх шатанд байх буюу хэргийг дахин хянан үзэх үед талаарх асуудлыг анхааралтай авч үзэх үед хөөн хэлэлцэх хугацаа зогсоно. Зарим нөхцөлд хөөн хэлэлцэх хугацаа дууссан хэргийг тодорхой хязгаарлагдмал хугацааны дараа сэргээж болох бөгөөд энэ нь *"reasonable period"* буюу тодорхой хэмжээний хугацаанд хийгдсэн байх ёстой.

Хүүхдэд холбогдох хувийн гэмтлийн нэхэмжлэлийн хувьд хөөн хэлэлцэх хугацаа нь 18 нас хүрэхээс нааш эхэлдэггүй онцгой зохицуулалттай. Сэтгэцийн хомсдолын улмаас ажлаа удирдаж чадахгүй байгаа хүмүүсийн хөөн хэлэлцэх хугацааг нөхөн сэргээх хүртэл сунгахаар зааж хамгаалагдсан байна.

Их Британи улсын иргэний хэргийн хөөн хэлэлцэх хугацааны зохицуулалт нь хохирогчдын эрхийг хамгаалах, шүүхийн үйл ажиллагааны үр дүнтэй байдлыг хангах, шударга ёсны хэрэгжилтийг дэмжих зорилгоор боловсруулсан, бусад улстай харьцуулахад зарим талаар бага хугацаатай байж болох боловч хүчтэй зохицуулалттай байдаг.

#### 4. Дүгнэлт, санал

Хөөн хэлэлцэх хугацааны ойлголт, түүний хэрэгжилт нь улс орнуудын эрх зүйн уламжлал, соёл, түүхээс хамаарч ялгаатай байдаг. Англи-Саксоны эрх зүйн бүл бүхий орнуудад хөөн хэлэлцэх хугацааны ойлголт бараг байдаггүй бөгөөд зөвхөн зарим төрлийн хөнгөн гэмт хэрэгт хөөн хэлэлцэх хугацааг хэрэглэдэг онцлогтой. Харин хөөн хэлэлцэх хугацааны ойлголтыг Эх газрын буюу Ром-Германы эрх зүйн бүл бүхий орнуудад гол төлөв хэрэглэдэг байна.

Англи-Саксоны болон Ром-Германы эрх зүйн бүлтэй улс орнууд болох ХБНГУ, БНФУ, Япон улс, АНУ, ИБУИНХУ улсуудын хөөн хэлэлцэх хугацааг судлан үзэхэд ХБНГУ болон Франц улсын гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацааны зохицуулалт нь тус бүрийн эрх зүйн тогтолцоо, онолын үндсээр ялгаатай боловч мөн зарим ижил төстэй үзүүлэлттэй байна. ХБНГУ болон Франц улс хоёрт нь гэмт хэргийн хөөн хэлэлцэх

хугацаа нь гэмт хэргийн төрлөөс хамаарч өөр өөр байдаг. ХБНГУ нь 3 жил болон 10 жил гэсэн хөөн хэлэлцэх хугацаатай байдаг бол Францад энэ хугацаа нь 6 жил, 20 жил зэрэг өөр өөр байна..

ХБНГУ болон Франц улс хоёрын хувьд гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацааг таслах зарчим нь тохиромжтой бөгөөд хэргийг мөрдөн байцааж эхлэх үед хугацаа тасарч эхэлнэ. Харин Франц улс нь зарим үед хөөн хэлэлцэх хугацааг сэргээж чаддаг. ХБНГУ болон Франц улсад ноцтой гэмт хэргүүд (жишээ нь, аллага, терроризм) нь хөөн хэлэлцэх хугацаа байхгүй буюу тэр хугацааг уртасгаж байхаар зохицуулсан байдаг. Энэ нь шүүхийн шийдвэр гаргах, гэмт этгээдийг байцаах, хэрэг хянан шийдвэрлэх хүндрэлийг арилгах зорилготой. ХБНГУ болон Франц улсын гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацааг зохицуулах хууль тогтоомж нь зарим талаараа төстэй бөгөөд зарим нь ялгаатай байна. Эдгээр улс орнууд гэмт хэргийн төрлөөс хамааран хөөн хэлэлцэх хугацааг уртасгаж, хязгаарладаг боловч тус улсын хууль зүйн тогтолцооны онцлог, гэмт хэргийн төрлөөс хамааран зохицуулалт нь ялгаатай байна.

Их Британи болон АНУ-ын гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацааг зохицуулах эрх зүйн зохицуулалт нь тодорхой ялгаатай боловч зарим талаар төстэй. Их Британи болон АНУ-ын иргэний хэргийн хөөн хэлэлцэх хугацааны зохицуулалт нь аливаа маргааны хурдтай шийдвэрлэгдэх, шударга ёс хэрэгжүүлэх болон нийгмийн итгэлцлийг хангах зорилгоор нэгтгэн зохион байгуулагдсан байна. Гэхдээ тус хоёр улсын хөөн хэлэлцэх хугацааны зохицуулалтад зарим ялгаа байгаагаас шалтгаалан, маргаан бүрийн онцлог, нөхцөл байдлаас хамааран өөр өөрийнхөө дүрмийг хэрэглэж байна.

60

Их Британи улсад шүүхийн шийдвэртэй холбоотой хөөн хэлэлцэх хугацаа нь 6 жил байна. АНУ-д шүүхийн шийдвэрийн хөөн хэлэлцэх хугацаа тухайн мужийн хууль тогтоомжтой холбоотойгоор илүү удаан, зарим тохиолдолд 10 жил хүртэл хугацаатай байж болно. Их Британи улсад зарим хүнд гэмт хэрэгт хөөн хэлэлцэх хугацаа байхгүй (жишээ нь, аллага), харин АНУ-д ихэнх тохиолдолд хамгийн урт хөөн хэлэлцэх хугацаа нь 10 жил байдаг. АНУ-д *discovery rule* буюу гэмт хэрэг илэрсэн өдрөөс хөөн хэлэлцэх хугацаа тоологддог бол Их Британи улсад энэ дүрэм илүү хязгаарлагдмал хэрэглэгддэг. Мөн Их Британи улс хөөн хэлэлцэх хугацааг баримт нотолгооны чанарт тулгуурлан тогтоохыг зорьдог бол АНУ-д хохирогчийн эрхийг хамгаалах нь чухал байж, гэмт хэрэг илэрсэн өдрөөс хөөн хэлэлцэх хугацаа тоологддог.

Ерөнхийдөө, хоёр улсын хөөн хэлэлцэх хугацааны зохицуулалт нь гэмт хэргийн хохирогчийг хамгаалах, гэмт хэрэгт хариуцлага хүлээлгэх болон шүүхийн шударга шийдвэр гаргахыг зорьдог боловч хоёр улсын хууль зүйн зохицуулалт зарим талаар ялгаатай байна. Иймд, хөөн хэлэлцэх хугацааг хэрэглэж буй арга зүй, түүний зохицуулалтуудын ялгаа нь тухайн улсын эрх зүйн практик, соёл болон эрх зүйн бүлийн онцлогоос шалтгаалан өөр өөр байна.

## 5. Эх сурвалж:

Хууль тогтоомжийн актууд:

1. Монгол Улсын Үндсэн хууль 2005.
2. Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал.,2010.
3. Монгол Улсын гадаад бодлогын үзэл баримтлал.2011.

Бусад эх сурвалж

4. Ц.Батбаяр., Д.Лүндээжанцан.1945 оны Чөлөөлөх дайн: Монгол ба дэлхий дахин. УБ., 2025
5. Өмирбек, С. (2023 оны 11 10). Гэмт хэргийг хөөн хэлэлцэх хугацаа, түүнийг тоолох журам харьцуулсан судалгаа. <https://omir.blogmn.net/116964/?cv=1-ээс>
6. Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын гадаад, дотоод орчны судалгаа, дүн шинжилгээ.УБ.,2014
7. <https://www.copytrust.ru/articles/Avtorskoe-pravo-Ispanii-ээс> Гаргасан
8. <https://www.gesetze-im-internet.de/bgb/-ээс> Гаргасан
9. <https://www.legislation.gov.uk/ukpga/1980/58-ээс> Гаргасан
10. Anthony Bradley, D.G. (2011). *Limitation periods under English law*. <https://www.pinsentmasons.com/out-law/guides/limitation-periods-under-english-law>
11. *Civil Code of French Republic (excerpts related to citizenship)*. (2013). <https://legislationline.org/taxonomy/term/21680-ээс> Гаргасан
12. Graham Virgo, L. P. (2006). *The Principles of the Law of Restitution (2nd хян.)*. <https://doi.org/10.1093/acprof:oso/9780199298501.003.0028-ээс> Гаргасан
13. *The Criminal Code z dnia 6 czerwca 1997 r. (Dz.U. tłum. Ю gb Nr 88, poz. 553), Chapter XI*. (огноо байхгүй).